



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 72

Номгон

Баянхонгор аймаг дахь  
Төрийн аудитын газрын зөвлөмжийн  
хэрэгжилтийг хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар өгсөн Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн зөвлөмжийг нэгдүгээр, Баянхонгор аймагт Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашгийн зөвлөмжийг хоёрдугаар, Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтын зөвлөмжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мазаалай парк, аймгийн төвд шинээр байгуулсан 10 км авто зам, Эрдэнэмандал хайрханы бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, үр дүнд шалгалт хийж дүнг 2017 оны II улиралд багтаан танилцуулахыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба /Б.Нармандах/-д үүрэг болгосугай.

3. Зөвлөмжийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



0117203

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны  
өдрийн 72 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

**НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ  
Г.БАТЖАРГАЛ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ,  
ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА НАР ТАНАА**


1. Орон нутгийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 21.2 дахь заалтын дагуу сумын суурь орлого болон суурь зарлагыг оруулсан дүнгээр баталж байх.

2. Аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс сумдын санхүүгийн албанаас төсөв баталсан, тодотгосон шийдвэрийг тухай бүр нь авч, орлого, зарлагын төлөвлөгөөний нэгтгэлийг хийх, жилийн эцэст төсвийн мэргэжилтэнтэй тодотгосон төсвийн хуваарийг байгууллага бүрээр нийлж Улсын төсөв болон Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийг тулган баталгаажуулж байх, Төсвийн тухай хуулийн 66.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3. Авто замын сангийн хөрөнгийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 67.1 "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ." гэсэн заалтын дагуу төсөл, арга хэмжээ нэг бүрээр төлөвлөгөө боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд оруулж, сангийн хөрөнгөөр хийсэн төсөл арга, хэмжээг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх.

4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн төсвийн мэргэжилтэн, аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн нар төсвийн

Ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд шинжилгээ хийж төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, төсөвт зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны талаар тайлбар тодруулга гаргаж байх. Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.



\_\_\_\_\_оо\_\_\_\_\_

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны  
өдрийн 72 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



**БАЯНХОНГОР АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН  
ХӨРӨНГӨӨР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ,  
ҮР ДҮН, ҮР АШИГТ ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

**НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛД**

1. Гүйцэтгэгчидтэй хийж байгаа гэрээг дүгнэж, гэрээнд захиалагчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаж ТБОНӨХБАУХАТухай хуулийн 40.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.3 дахь заалтыг зөрчиж, аймгийн ГХБХБГазар, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга нар хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан, санхүүжилт олгосон тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, цаашид зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах.

3. Улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авсан барилгын ашиглалтын байдалд хяналт тавьж, чанарын шаардлага хангахгүй байгаа төсөл, арга хэмжээний зөрчлийг тухай бүр нь арилгуулж, Барилгын тухай хуулийн 12.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**ХОЁР. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ**

1. Харьцуулалтын аргаар хийгдэж буй зураг, төсөв шаардсан, алслагдсан сумын хувьд гүйцэтгэгчид ажлыг газар дээр нь үнэлэх, төсөв боловсруулах, бусад тендерийн материалыг бүрдүүлэх хугацааг тооцоолж худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.

2. Ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний үр дүнг хянан үзэж, чанаргүй ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийг дахин худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байх.

ГУРАВ. АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ



1. Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Барилгын баталгаат хугацаанд хүлээж авсан барилгын ашиглалтын байдалд дахин хяналт хийж, Баянговь, Гурванбулаг сумын сургуулийн чанаргүй хийсэн ажлыг 2017 оны 06 дугаар сарын 15-ны дотор зөрчлийг арилгах.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны  
өдрийн 72 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
2016 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД  
ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

**НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА Ц.ОТГОНБАЯР ТАНАА**

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1 дэх заалтын дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавих хяналтын хороог сумын ИТХ-ын дэргэд байгуулж ажиллуулах, тайланг ИТХ-аар хэлэлцэж, дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх.

**ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ ТАНАА**

1.Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг хууль журмын дагуу боловсруулж, ажлын хэсэг байгуулж, баг, хорооны хурал, Иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлж Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;

2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг 2016 онд давтан гаргасан, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй сумдын Засаг дарга нарт арга зүйн зөвлөмж өгч ажиллах;

3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг журмын дагуу сонгон шалгаруулах;

4. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10 дахь заалтын дагуу сумдаас тайланг авч хэлэлцэн, үр дүнг тооцож ажиллах.

5. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2012-2015 онуудад ОНХС-аас олгосон зээлийн авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг улирал бүр тооцож ажиллах.

ГУРАВ. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГА Ч.МӨНХЦЭЦЭГ ТАНАА



1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж, ашиглалтанд хүлээн авсан хөрөнгийн эзэмшигчийг аймгийн ИТХ-аар тогтоолгож, хөрөнгөд бүртгэсэн эсэхэд хяналт тавьж ажиллах.

2. Ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний үр дүнг хянан үзэж, чанаргүй ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийг дахин худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байх.

ДӨРӨВ. СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА, ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Зардлыг хэмнэх замаар бий болсон эх үүсвэр болон ОНХС-ийн оны эхний үлдэгдэл, тайлант онд бий болсон эх үүсвэрийг сумын ИТХ-аар баталж байх;

2. Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, багийн ИНХ-д оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эдгээртэй холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу баримтжуулах

3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг журмын дагуу сонгон шалгаруулж, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгэж, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.13, 3.19 дэх заалтуудыг хэрэгжүүлэх.

4. Сумын ИТХ-ын дэргэд хяналтын хороо байгуулж, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 10.1 дэх заалтын дагуу тогтоосон хугацаанд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБХэлтэст хүргүүлэх;

5. Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг хууль журмын дагуу боловсруулж, ажлын хэсэг байгуулж, багийн ИНХ болон Иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлж Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;

6. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээр дэмжигдээгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталдаг явдлыг зогсоож, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.

Нийцлийн аудитаар тогтоогдсон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 07 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх



\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_